

Монгол Улс дахь бага насны хүүхэдтэй ээжүүдийн агаарын бохирдолтой үеийн нийгмийн сайн сайхан байдал

Photovoice буюу дүрс зургийн дуу хоолой
аргаар нийгмийн асуудлыг судлахуй



Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) нь Монгол Улсад мэргэжлийн, хараат бус судалгааг институцийн түвшинд, тогтвортой хэрэгжүүлж буй анхны байгууллагуудын нэг юм. Бидний эрхэм зорилго бол дэлхийн жишигт нийцсэн, хараат бус судалгаа хүргэдэг, Монголын хөгжлийн салбарт тулгуурласан мэдлэгийн төв болох явдал юм. Бид олон нийтэд хараат бус, чанартай мэдээллийг түгээж, сайн сайхан нийгмийг цогцлоох, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хоорондын хамтын ажиллагааг дэмжих, Монголын хүн амын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорьж байна. IRIM нь “Азийн Нийгмийн сайн сайхан байдлын консорциум” болон “Олон улсын Социологийн холбоо”-ны гишүүн юм.

Бидэнтэй холбогдох:

Цахим шуудан: contact@irim.mn

Цахим хуудас: www.irim.mn Фэйсбүүк /Твиттер хуудас: @IRIMongolia

Тайланг эш татах: IRIM (2024), “Бага насны хүүхэдтэй ээжүүдийн агаарын бохирдолтой үеийн нийгмийн сайн сайхан байдлын судалгаа” Улаанбаатар. IRIM судалгааны хүрээлэн

Зохиогчид: Лхагвын Цэлмэгсайхан, Түмэнжаргалын Элбэрэл, Ганзоригийн Жаргалмаа, Лхагваноровын Дашзэвэг, Мөнхтөмөрийн Саруул

Дизайнер: Тогтохбаярын Азбилэг

Мэдэгдэл: Энэхүү тайлангийн агуулга нь судалгааны багийн үзэл бодол ба IRIM судалгааны хүрээлэнгийн албан ёсны байр суурийг төлөөлөхгүй болно.

Зохиогчийн эрхийн талаар мэдээлэл: Энэхүү тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурьдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно.

Судалгааны тухай

IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн бие даасан бүтээгдэхүүн болох “Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-г 2016 оноос хойш жил бүр гүйцэтгэж ирсэн. Уг судалгаа нь нийгмийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулахад тусалж, баримт нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг дэмжихэд хувь нэмрээ оруулах зорилготой.

Судалгааны хүрээнд жил бүр нийгмийн ялгаатай бүлгүүдийг зорилтот түүврээр сонгон авч тухайн бүлгийн нийгмийн сайн сайхан байдлыг шинжлэх ухааны арга, аргачлалаар цуглуулсан дата мэдээлэлд тулгуурлан тайлбарлахыг зорьдог билээ. Энэ удаагийн 2023-2024 оны тайландаа бид Улаанбаатар хотод оршин сууж буй иргэдийн амьдралын чанарт үлэмж нөлөө үзүүлж буй агаарын бохирдлын асуудлыг онцолж, үүний нөлөөлөлд хамгийн өртөмтгий бүлгүүдийн нэг болох бага насны хүүхэдтэй ээжүүдийн сайн сайхан байдлыг судаллаа. Агаарын бохирдол Улаанбаатар хотын оршин суугчдын субъектив сайн сайхан байдалд ихээр нөлөөлж байгаа нь илэрхий хэдий ч тодорхой арга зүйгээр судалсан судалгааны ажил хомс байна.

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн хүйтэн нийслэл хотуудын нэг гэдэг утгаараа хүйтний улирлыг давахын тулд тодорхой хэмжээний агаарын бохирдол үүсэх хэдий ч сүүлийн 10 жилд агаарын бохирдол дээд цэгтээ хүрч, 2024 оны 12 сарын байдлаар Улаанбаатар хотын PM2.5 хэмжээ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөгдөх жилийн дундаж хэмжээнээс 6.9 дахин өндөр байна¹.

Гэрхорооллынайлууд, бага оврынуурынзуухууд нүүрсийг их хэмжээгээр түлж агаар мандалд бохирдлыг бий болгохоос гадна, цахилгаан станц, автомашин зэрэг бусад бохирдуулагч эх үүсвэрүүд олон байдаг. Улаанбаатар хот дахь тоосонцрын дундаж агууламж 2011 онд жилийн 365 хоногийн дунджаар 237 өдөр хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс давж байсан бол 2018 онд 338 болж өссөн зэрэг олон тоон үзүүлэлтүүд Улаанбаатар хотын агаарын чанар жил ирэх тусам улам муудсаар байгааг илтгэнэ (NSO, 2019).

Монголчуудын гадаад орчноос хамаарсан буюу аюулгүй байдал, байгаль орчин, улс орны нийгэм, эдийн засгийн байдал зэрэгт хандах сэтгэл ханамж бусад орнуудтай харьцуулахад доогуур байгааг, сэтгэл хөдлөлийн үзүүлэлтүүдээр хөдөө орон нутагтай харьцуулахад хот суурин газарт амьдарч буй хүмүүс илүү бага, мөн улирлын хувьд өвлийн улиралд хамгийн бага сэтгэл хөдлөлтэй байгааг өмнөх судалгааны ажлуудад тодорхойлсон байна (Монголын Нийгмийн Сайн Сайхан Байдлын Судалгаа, 2019). Тэгвэл энэхүү судалгаагаар өмнөх тоон судалгаадын үр дүнг чанарын мэдээллүүдээр баяжуулахыг зорьж, “дүрс зургийн арга” хэмээх оролцооны, чанарын аргыг ашиглан Улаанбаатарын гашуун өвлийг хохирол багатайгаар давахын тулд ээжүүд ямар их золиос гаргах шаардлага тулгардаг, тэдэнд гэр бүл, нийгмийн зүгээс үзүүлж буй ямар дэмжлэг, нийгмийн капиталууд байгааг социологийн шинэлэг арга зүйгээр судалж, тайлбарлахыг зорилоо.

¹ [Ulaanbaatar Air Quality Index \(AQI\) and Mongolia Air Pollution | IQAir](#)

ДЭМБ-ын шинэчилсэн дэлхийн агаарын чанарын зааварчилгаанд PM2.5 хэмжээ жилийн дунджаар 5 $\mu\text{g}/\text{m}^3$ -ээс хэтрэхгүй байхыг зөвлөсөн бөгөөд энэ нь хүний эрүүл мэндийг хамгаалахад зохист хэмжээ юм ([WHO Global Air Quality Guidelines](#)).

Судалгааны хамрах хүрээ ба үндсэн ойлголтууд

Энэхүү судалгаа нь гурван үндсэн ойлголтын уялдаа холбоог судалсан. Нэгдүгээрт, агаарын бохирдол ээжүүдийн сайн сайхан байдал, амьдралын чанарт хэрхэн нөлөөлж байгаа, хоёрдугаарт энэхүү орчны таагүй байдлаас үүдэлтэй сорилтыг даван туулах ээжүүдийн тэсвэртэй байдал хэр хэмжээнд байгаа, гуравдугаарт, ээжүүдийн тэсвэртэй байдлыг дэмжихэд нийгмийн капиталын үүрэг, оролцоо ямар түвшинд байгааг тодорхойлсон болно. Эдгээр гол гурван онолын ойлголтыг дараах харилцан хамааралтай байдлаар авч үзсэн.

Дүрс 1. Судалгааны гол ойлголтуудын харилцаа хамаарал



Сайн сайхан байдал (Well-being)

Хувь хүний сайн сайхан байдал нь зөвхөн материаллаг баялгаас гадна хүмүүсийн амьдралын чанарт хувь нэмэр бүхий субъектив туршлага, нийгмийн харилцаа холбоо, эрүүл мэнд, хувь хүний хөгжил, сэтгэл ханамж зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг багтаасан ойлголт юм. Хүний сайн сайхан байдлыг дан ганц эдийн засгийн үзүүлэлтүүдээр тодорхойлох нь хангалтгүй болж ирсэн учраас илүү цогцоор авч үзэх арга хандлагууд олон улсад гарч ирсний нэг нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан “Сайн сайхан байдлын хүрээ” аргачлал юм. Энэхүү аргачлал нь хувь хүний сайн сайхан байдлыг илтгэх гурван бүрэлдэхүүн хэсэг бүхий цогц үзүүлэлтүүдийг санал болгодог. Нэгдүгээрт, орлого, эд баялаг, ажлын чанар, орон сууц зэрэг хүчин зүйлсийг багтаасан *материаллаг нөхцөл* нь чухал үүрэгтэй.

Эдгээр элементүүд нь хүний үндсэн хэрэгцээг хангах, зохистой амьдралын стандартыг бий болгох үндсэн суурь юм. Гэсэн хэдий ч сайн сайхан байдал нь материаллаг баялгаар хязгаарлагдахгүй, *амьдралын чанарын тухай* илүү өргөн ойлголтыг агуулдаг. Энэхүү *амьдралын чанар* хэмээх хоёр дахь хэмжигдэхүүн нь эрүүл мэнд, ажил амьдралын тэнцвэрт байдал, нийгмийн харилцаа холбоо, хүрээлэн буй орчны чанар зэрэг олон хүчин зүйлийг хамардаг. Эдгээр элементүүд хамтдаа хувь хүний амьдралын сэтгэл ханамж, аз жаргалд хувь нэмрээ оруулж, сайн сайхан байдлын олон талт мөн чанарыг тодотгож өгдөг. Гуравт нь, сайн сайхан байдлыг авч үзэхэд *хувь хүмүүс өөрсдийн бүрэн чадавх, нөөц бололцоондоо хүрэх боломжууд*. Үүнд боловсролын хүртээмж, ажил эрхлэх боломж, нийгмийн харилцаа холбоо, нийгэмд оролцох оролцоо зэрэг хүчин зүйлс багтана.

Эдгээр боломжууд нь хувь хүмүүст амьдралаа сэтгэл хангалуун авч явах, өөрсдийн чадвараа бүрэн дүүрэн гаргах бололцоог өгч, улмаар сайн сайхан байдал нь хувь хүний бие даасан, хүчирхэг байдалтай салшгүй холбоотойг нөхцөлдүүлж байдаг.

Тэсвэртэй байдал (Resilience)

Тэсвэртэй байдал хэмээх ойлголт нь нийгмийн янз бүрийн нөхцөл байдалд хувь хүн аливаа саад бэрхшээлийг даван туулах, сайн сайхан байдлаа хадгалах чадварыг ойлгоход чиглэсэн нийгмийн шинжлэх ухааны ухагдахуун юм. Тэсвэртэй байдал нь Латин хэлний “resilire” буюу “буцах/дахин эхлэх” гэсэн үгнээс гаралтай бөгөөд, сорилт бэрхшээлийн өмнө дасан зохицож, нөхөн сэргэж, цэцэглэн хөгжих чадвар гэсэн агуулгуудыг тээдэг (Ungar, 2012). *Тэсвэртэй байдал* нь реактив болон проактив даван туулах гэсэн хоёр нийтлэг хэлбэрээр илрэх ба тус бүртээ хувь хүний тэсвэр, даван туулах арга замыг ялгаатайгаар тодорхойлдог. *Реактив (хэвийн) даван туулах тэсвэртэй байдал* нь аливаа сорилт бэрхшээл тохиолдсоны дараагаар хариу үйлдэл үзүүлэх байдлыг хэлэх ба голцуу шууд үүдэн гарах зовлон зүдгүүрийг багасгах, стресс үүсгэгчийн нөлөөг бууруулахад чиглэдэг (Folkman & Moskowitz, 2004).

Эдгээр хариу үйлдлүүдэд ихэвчлэн нийгмийн дэмжлэг хайх, асуудлыг шийдвэрлэхэд гар бие оролцох эсвэл сэтгэл хөдлөлийг удирдах, нийгмийн сүлжээний тэнцвэрийг хангах зэрэг арга техникүүд багтдаг.

Үүний эсрэгээр, *проактив (идэвхтэй) даван туулах тэсвэртэй байдал* нь болзошгүй стресс үүсгэгчийг урьдчилан таамаглах хариу үйлдэлд төвлөрч, бэрхшээлээс урьдчилан сэргийлэх эсвэл бууруулахын тулд бэлтгэл, төлөвлөлт, идэвхтэй оролцоог чухалчилдаг (Aspinwall & Taylor, 1997). Проактив даван туулах чадвар нь нийгмийн капиталыг бий болгох, орон нутгийн тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, нийгмийн тэгш бус байдал, эмзэг байдлыг арилгахын тулд бүтцийн өөрчлөлт хийхийг хөхиүлэн дэмжих зэргээр илэрч болно.

Нийгмийн капитал (Social Capital)

Нийгмийн капитал гэдэг ойлголт нь нийгмийн эв нэгдэл, олон нийтийн тогтвортой байдал, хувь хүний сайн сайхан байдалд гүн гүнзгий нөлөө үзүүлдэг. Энэхүү ойлголт нь Пьер Бурдьё, Роберт Путнам зэрэг социологичдын бүтээлээс анхлан урган гарсан бөгөөд нийгмийн капиталыг нийгмийн сүлжээ, харилцаа холбоо, нийтлэгийн бүтцэд хамаарах нөөц гэж тодорхойлсон. Эдгээр нөөц нь хувь хүмүүс болон бүлгүүдийн хамтын ажиллагаа, итгэлцэл, харилцан ойлголцлыг хөнгөвчилдөг (Bourdieu, 1986; Putnam, 2000). Эрдэмтэд онолын хүрээнд нийгмийн капиталын *ойр дотнын, дамжуулах, холбох (bonding, bridging, linking) үүрэг бүхий* гэсэн гурван ялгаатай функцийг тодорхойлсон бөгөөд тэдгээр нь тус бүртээ нийгмийн харилцааны динамик, нийтлэгийн хамтын үйлдлийг бүрэлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Эдгээрээс, *ойр дотнын үүрэг бүхий нийгмийн капитал (bonding social capital)* гэдэг нь нийгэм-эдийн засгийн хувьд ижил төстэй бүлгүүд дэх хувь хүмүүсийн хооронд хүчтэй холбоо, эв нэгдлийг бий болгох нийгмийн сүлжээний чадавхыг илэрхийлдэг (Granovetter, 1973). Хамтын ижилсэл, хэм хэмжээ, үнэт зүйлсээр тодорхойлогддог эдгээр ойр дотнын нягт харилцаа холбоо нь хүмүүст сэтгэл санааны дэмжлэг, эв эе, харилцан туслах эх үүсвэр болохын зэрэгцээ, хувь хүний өөрийн ойрын хүрээлэлдээ харьяалагдаж буй, ижил дасал болж буй мэдрэмжийг нь өргөж байдаг.

Үүний эсрэгээр, *дамжуулах үүрэг бүхий нийгмийн капитал (bridging social capital)* нь нэг төрлийн гэхээсээ илүү нийгмийн олон янзын бүлгүүд, нийтлэг хоорондын харилцан үйлчлэлийг нөхцөлдүүлэх холболтын үүргийг гүйцэтгэнэ (Putnam, 2000). Өөрөөр хэлбэл, энэхүү дамжуулах үүрэг нь янз бүрийн ялгаатай гарал үүсэл, сонирхол, харьяалал бүхий хүмүүс хоорондын харилцаа холбоог хамардаг бөгөөд, тэдний дунд мэдээ мэдээлэл, нөөц баялаг, боломжуудыг түгээх нөхцөлийг бүрдүүлдэг.

Эцэст нь, *холбох үүрэг бүхий нийгмийн капитал (linking social capital)* нь хувь хүн, бүлэг, албан ёсны институц, байгууллага, эсвэл нийгмийн доторх эрх мэдлийн бүтцийн холбоог хамаарна (Szreter & Woolcock, 2004). Энэхүү нийгмийн капиталын хэлбэр нь нийгэм дээрх нөөц баялаг, үйлчилгээ, боломжийг хуваарилах шийдвэр гаргаж байдаг эрх мэдэл бүхий төр, иргэний нийгэм эсвэл нөлөө бүхий хувь хүмүүстэй харилцах харилцааг зохицуулдаг. Эдгээр холбох үүрэг нь системийн тэгш бус байдлыг арилгах, нийгмийн шударга ёсыг дэмжих, олон нийтийн хөгжлийн санаачилгыг ахиулах зорилгоор нөөц баялгийг дайчлах, хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэхэд тусалж байдаг.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилго

Судалгаагаар дараах асуултуудад хариулт өгөхийг зорьсон:

1. Агаарын бохирдол болон түүнээс үүдэлтэй асуудлуудыг ээжүүд өдөр тутамдаа хэрхэн даван туулж байна вэ?
2. Агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлаа хэрхэн шийдвэрлэж, ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байна вэ? Ээжүүд хэрхэн урьдчилан сэргийлж, даван туулж байна вэ?
3. Ээжүүдийг эдгээр асуудлыг даван туулахад нийгмийн капитал хэр дэм болдог вэ? Нийгмийн капиталын үнэ цэнийг хэрхэн авч үзэж байна вэ?

Судалгааны арга зүй, хамрах хүрээ

Судалгааг (1) дүрс зургийн арга, (2) фокус бүлгийн хэлэлцүүлэг, (3) гүнзгийрүүлсэн ярилцлага зэрэг чанарын олон талт аргуудад тулгуурлан гүйцэтгэсэн. Эдгээрээс дүрс зургийн аргаар судлах буюу Photovoice method нь харьцангуй шинэ тутам бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн чанарын судалгааны арга юм. Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, судалгааны оролцогчоор өөрсдөөр нь нийгмийн асуудлуудыг илрүүлэхэд ашигладаг. Мөн оролцогч өөрөө зургаар асуудлыг баримтжуулж, авсан зургаа тайлбарлах явцдаа

давхар мэдлэг олж авч, чадавхижиж байдгаараа онцлогтой. Уг аргыг COVID-ын хязгаарлалттай, хөл хориотой байх үеийн нөхцлөөс үүдэн хөгжсөн гэж үздэг.

Мэдээлэл цуглуулалтад Улаанбаатар хотод оршин суудаг 10 ээж сайн дураараа оролцсон. Ээжүүдийг сонгохдоо, нийслэлийн агаарын бохирдол хамгийн ихтэй дүүргүүдэд амьдардаг, сургуулийн өмнөх, болон сургуулийн насны хүүхэдтэй, гэр хороолол болон орон сууцанд амьдардаг зэрэг ялгаатай нөхцлүүдийг төлөөлөх байдлыг харгалзаж сонгосон (Хүснэгт 1). Мэдээлэл цуглуулалт нэг сарын хугацаанд үргэлжилсэн ба судалгаанд оролцсон ээжүүд өгсөн чиглэлийн дагуу өдөр тутмын амьдралаа зургаар баримтжуулж, дундын хаалттай фейсбүүк группт байршуулж, зургуудаар харуулсан нөхцөл байдлаа тайлбарлаж, хэлэлцүүлэх зорилготой бүлгийн хэлэлцүүлэг болон нэмэлт чанарын ярилцлагуудыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэсэн.

Хүснэгт 1. Судалгааны түүврийн задаргаа

Байршил	Хүрээ	Сургуулийн өмнөх насны (2-5 нас) хүүхэдтэй	Сургуулийн насны (6-11 нас) хүүхэдтэй
Улаанбаатар	Гэр	3	3
	Орон сууц	2	2
Нийт		5	5

Дүрс 2. Судалгааны үйл явц



Мэдээлэл цуглуулалтын өмнө оролцогчдод судалгааны зорилго зорилттой холбоотой ерөнхий ойлголтоос гадна, зураг хэрхэн авах, дүрс зурган баримтжуулалт хийхдээ ёс зүйн асуудлыг хэрхэн хангах, аюулгүй байдлын зааварчилгаа зэрэг мэдээллүүдийг олгох нэгдсэн сургалт хийж зааварчилгаа өгсөн. Ингээд агаарын бохирдлын хамгийн идэвхтэй үе болох 12 сарын 16-1 сарын 16-ны хооронд

оролцогчдын тодорхой чиглэлүүдээр өдөр тутамдаа оруулж буй зургуудыг судалгааны баг нэгтгэн, ажиглалт хийж, коммент өгөх байдлаар тухайн цаг мөчид нь тайлбар авах, тодруулга хийх байдлаар харилцаж, ажилладаг байв. Судалгааг гүйцэтгэсэн дараалал, үйл явцын дэлгэрэнгүйтэй Дүрс 2-оос танилцах боломжтой.


БҮЛЭГ #1

Агаарын бохирдлын үе дэх ээжүүдийн сайн сайхан байдал

Агаарын бохирдлын үе дэх ээжүүдийн сайн сайхан байдлыг хэмжихдээ бид “Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-ын сайн сайхан байдлын хэмжүүрийг гол шалгуур болгон ашигласан². Шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд судалгаанд хамрагдсан 10 ээжийн сайн сайхан байдлыг зургаар судалж, агаарын бохирдолгүй үеэс ялгагдах онцлогуудыг чанарын ярилцлагаар тодруулж үр дүнг нэгтгэв. Сайн сайхан байдлын шалгуур үзүүлэлт тус бүрийн агаарын бохирдлын үед өөрчлөлтөд өртөж буй байдлыг Дүрс 3-д харууллаа.

Судалгааны үр дүнгээс харахад агаарын бохирдол ихсэх үед ээжүүдийн сайн, сайхан байдалд хүчтэй өөрчлөлт гардаг бөгөөд ерөнхий буурах хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, ээжүүдийн “нийгмийн харилцаа”, “эрүүл мэнд”, “эдийн засаг”, боловсрол”-ын чиглэлд гол өөрчлөлтүүд орж, сайн сайхан байдлыг нь бууруулдаг байна. Гол өөрчлөлт, нөлөөлд өртөж буй эдгээр 4 үзүүлэлттэй холбогдох судалгааны үр дүнг дэлгэрүүлэн доорх дэд бүлгүүдэд тайлбарлалаа.

Дүрс 3. Агаарын бохирдлын үед ээжүүдийн сайн сайхан байдалд гарч буй өөрчлөлтүүд, сайн сайхан байдлын хэмжүүр /шалгуур үзүүлэлт/ тус бүрээр



¹ Measuring Well-being and Progress: Well-being Research, Centre on Well-being, Inclusion, Sustainability and Equal Opportunity (WISE), OECD. Source: <https://www.oecd.org/wise/measuring-well-being-and-progress.htm>

Нийгмийн харилцаа

Агаарын бохирдолтой улиралд ээжүүдийн гэртээ байх хугацаа илүү нэмэгддэг ба энэ нь агаарын чанар муудсанаас үүдэлтэйгээр хүүхдийнхээ эрүүл мэндэд санаа тавих, аливаа эрсдэл учрахаас сэргийлэх зорилгоор хүүхдэдээ илүү цаг зарцуулах шаардлага үүсдэгтэй холбоотой. Хүүхэд, гэр бүлдээ тавих анхаарал, санаа зовнил нь чөлөөт цагаа ихэвчлэн гэртээ өнгөрүүлэх, зарим тохиолдолд ажлаасаа чөлөө авах, цахим хэлбэрээр

ажиллах гэсэн сонголтуудад хөтөлдөг бөгөөд улмаар нийгмийн харилцааг нь багасгах үндсэн шалтгаан болж байна. Нийгмийн үйл ажиллагаанаас ийнхүү хөндийрөх нь тэдний харилцааг хязгаарлаад зогсохгүй сайн сайхан байдал нь буурахад нөлөөлдөг. Нийгмийн харилцаанаас үүдэлтэй хэрэгцээ, сайн сайхан байдлаа сайжруулах оролдлого нь найз нөхөд, хамаатан садан, ижил бүлгийн нийгмийн сүлжээ (ээжүүдийн групп)-нд харилцаагаа идэвхжүүлэх замаар илэрдэг ч байнгын бус, давтамж бага байна.

Зураг 1. Нийгмийн сүлжээгээр дамжуулан үзэл бодлоо илэрхийлж буй байдал



Зургийн тайлбар: Нийгмийн сүлжээгээр дамжуулан оролцож үзэж бодлоо илэрхийлж байсан. Ер нь дуу хоолойгоо хүргэх нэн сонирхолтой байгаа ч биечлэн бол үнэхээр амждаггүй учир цахимаар л дуу хоолой хүргэж байна. Жишээ нь: өөрийн цахим хуудсаар зураг нийтлэх, санал асуулгад идэвхтэй байхыг хичээдэг.

Зураг 2. Амралт сунгах хүсэлтээ илэрхийлж буй байдал



Зургийн тайлбар: Миний хувьд декритнээсээ ажилдаа хүүхдээ нэг нас таван сартайд орохоор хүсэлт өгөөд тэр хугацаандаа ч болов ажилдаа ормоор байсан ч ар гэрийн байдал, нөхрийн ажлын онцлог болон хүүхэд харах хүнгүй цэцэрлэгийн амралт эхэлж байсан тул сунгах хүсэлт өгсөн. Гэхдээ цаанаа нь ажлаа хийж нийгмийн харилцаанд орох битүүхэн хүсэл нуугдаж байсан.

Зураг 3. Хүүхэдтэй ээжүүдийн өөрийгөө хөгжүүлж буй байдал



Зургийн тайлбар: Хүүхэдтэйгээ аль болох цагийг өнгөрөөж, кино үзэх гадуур шинэ зүйлсийг танин мэдүүлээр байдаг ч агаарын бохирдолтой үед гадуур гарах нь асуудал болсон. Өөрийгөө хөгжүүлэх зүйлсийг хийхэд ч агаарын бохирдолтой үед зөвхөн гэртээ байх л сонголтыг өгч байна.

Эрүүл мэнд

Агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн байдалд үүсэх эрсдэл нь ээжүүдийн сайхан сайхан байдалд хүчтэй нөлөөлөл үзүүлж байна. Гэхдээ ээжүүдийн өөрсдийн эрүүл мэндийн асуудалд санаа зовохоос илүүтэй гэр бүл буюу хүүхдүүдийн эрүүл мэндэд маш их санаа зовдог бөгөөд энэ нь сайхан байдлыг нь бууруулах хандлагыг бий болгодог. Уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын нөлөөгөөр сүүлийн жилүүдэд жирэмсэн эмэгтэйд

болон ургийн жин, амьгүй дутуу төрөлтийн тохиолдлууд ихэссээр байгаа. Амьгүй төрөлтийг судлахад жирэмсэн эмэгтэйчүүдийн ихэнх нь гэр хорооллын дүүргүүдийн харьяалалтай, дутуу төрөлтийн түвшин 1000 амьд төрөлтөд 15.5 байсан байна. (ЖҮХ 2020).

Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлийг бууруулах маш олон төрлийн арга замуудыг авч хэрэгжүүлдэг ба үүнд шаардлагатай санхүү, цаг зав, мэдлэг мэдээллийн нөөцүүд ихээхэн шаардлагатай байна.

Зураг 4. Утааны улирлыг даван туулж буй байдал



Зургийн тайлбар: Утааны улирал эхлэж, 12 сар гараад хүүхэдтэйгээ 3 дахь удаагаа эмнэлэгт үзүүлж байна. Өмнөх хоёр удаа үзүүлэхэд антиботикийн төрлийн эм бичиж өгөөгүй, зөвхөн вирусны эмнүүд өгсөн. Тэр нь бүрэн эдгээгүй даамжирсаар одоо антибиотик эмчилгээ эхлүүлэхээр боллоо.

Зураг 5. Өвлийн улиралд хүүхэд нь өвдсөн ээжийн сэтгэл зүйн байдал



Зургийн тайлбар: Одоо хүүхдээ өвдөх тоолонд би сэтгэл гутралд өртдөг. Яг нэг жилийн өмнө миний хүү ханиад хүрээд хатгаа болж, хүчил төрөгчийн дутагдал гэсэн оноштойгоор сэхээнд орсон юм. 2 настай хүүхэд ээжээсээ хол 3 хоног сахиур байхгүй шөнийг өнгөрүүлсэн. Би 3 хоног эмнэлгийн гадаа юу ч хийж чадахгүй хаалганы завсраар л хүүхдээ хардаг байсан. Сэхээн амьдруулах тасгаас шилжээд 5хоног эмнэлэгт хэвтээд гарахад эмч дахиж хүүхдээ ханиад хүргэж болохгүй, хэрвээ хүрвэл уушигны архаг өвчин тусах магадлал өндөр гэж хэлж байсан.

Эдийн засаг

Өвлийн улирлын онцлогоос хамааран өрхийн санхүүд нэмэлт зардал ихээхэн шаардагддаг тул ээжүүдийн сайн сайхан байдалд эдийн засгийн нөхцөл байдал хүчтэй өөрчлөлт оруулах буюу бууруулах хандлагатай байна. Ялангуяа утаанаас үүдэлтэйгээр Улаанбаатар хотод олон

төрлийн өвчлөл нэмэгдэх, үүсэх хандлагатай байдаг тул эрүүл мэндийн хамааралтай санхүүгийн дарамт ээжүүдэд их тулгардаг. Санхүүгийн нөөц хязгаарлагдмал байдгаас гэр бүлийн гишүүд тэр дундаа хүүхдүүд нь өвчин эмгэг тусах үед ээжүүд өөрсдөөс нь хамаарсан гэж үзэж стресс, сэтгэл санааны дарамтад өртөх байдал түгээмэл байна.

Зураг 6. Ханиад, томуу эдийн засагт нөлөөлж буй байдал



Зургийн тайлбар: Өвлийн улиралд утаа их, ханиад томуу ихэсдэг учраас хамгийн наад зах нь нэмэлт витамин ууж дархлаагаа дэмжих зайлиггүй шаардлага үүсдэг. Өвлийн улиралд бага насны хүүхдүүд утаанаас үүдэж ханиад хүрэх нь элбэг тохиолддог. 1 хүүхэд ханиад хүрэхэд 1 удаадаа 70-100 мянган төгрөгөөр эм тариа авдаг. Тэгэхээр өвлийн улиралд агаарын бохирдлоос болж өрхийн санхүүд маш их ачаалал ирдэг гэсэн үг...

Зураг 7. Өвөл цэвэр агаарыг мөнгөөр худалдаж авдаг



Зургийн тайлбар: Би өвөл хүүхдүүдээ хашаандаа авч гарч савхилуулахаас ч айдаг. Утааны төв цэг гэж хэлж болохоор газар амьдардаг учраас тэр. Бүхэл бүтэн 3 сар хүүхдүүдээ гэрээс гарахгүй байлгах нь буцаад эрүүл мэнд мөн өсөх, хөгжих, танин мэдэхэд нь сөрөг нөлөөтэй учир хотоос зайдуу газар очоод 2,3 хоног байлгахыг хичээдэг. Мэдээж хотоос гарахад явах бензин, хоол очоод байрлах газар бүгд төлбөртэй. Уг нь гэрээсээ гараад л зун шиг хүүхдүүдээ чөлөөтэй 20-30 минут тоглуулж, наадуулахыг хүсэж байна...

Боловсрол

Өвлийн улиралд боловсролын асуудал тэр дундаа хүүхдүүдийн сургууль, боловсролын асуудал ээжүүдийн хувьд анхаарах үндсэн асуудал болдог тул тэдний сайн сайхан байдалд шууд нөлөөтэй хүчин зүйлд зүй ёсоор тооцогдож

байна. Хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт хүргэж өгөх, авах, тасалдуулахгүй байх, хичээлийг нь давтуулах асуудал ээжүүдийн үндсэн үүрэг болдог ба ажил эрхэлдэг ээжүүдийн хувьд ажил болоод хүүхдийн боловсролын асуудлыг давхар зохицуулах шаардлагаас үүдэн их хэмжээний ачаалал, сэтгэл санааны стресст өртөх тохиолдлууд байна.

Зураг 6. Ханиад, томуу эдийн засагт нөлөөлж буй байдал



Зургийн тайлбар: Хүүхдийн хичээл 7 хоногийн өмнө эрт амрахаар болсон. Энэ нь хүүхдийн эрүүл мэндийн хувьд аюулгүй санагдаж байна. Гадагш гарахгүй байхад ханиад хүрэх нь бага. Өвлийн улиралд ийм хорт утаанаас болж ханиад маш их хүрдэг. Гэрээс цөөн хоног хичээллэж байгаа нь утаа, ханиад томуу бага хүрэх сайн талтай ч хичээлээ бүрэн ойлгохгүй, хоцрогдох, боловсролын чанар муудах гээд нөгөө талаараа бас хүүхдэд хохиролтой л байна...

БҮЛЭГ #2

Агаарын бохирдлын үе дэх ээжүүдийн тэсвэртэй байдал ба авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Өмнөх бүлэгт тайлбарласанчлан концепцийн хувьд аливаа гамшиг, эрсдэлийн үе дэх иргэдийн тэсвэртэй байдлыг реактив болон проактив гэсэн хоёр төрөлд хуваан судалгааны ажлуудад нийтлэг авч үздэг (Хүснэгт 2). Реактив тэсвэртэй байдал нь гамшиг эрсдэлийн дараа учирсан хохирлыг нөхөн сэргээх буюу эргэн хэвийн нөхцөл байдалд оруулахад төвлөрдөг бол проактив тэсвэртэй байдал нь гамшиг эрсдэл тохиохоос өмнө тухайн эрсдэлийг боломжтой гэж үзэж, байнгын бэлэн байдалд байхад (act of anticipation and active waiting) төвлөрдгөөрөө ялгаатай. Уг тодорхойлолт, ангиллын дагуу судалгаанд хамрагдсан 10 ээжид агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлуудыг даван туулах тэсвэртэй байдал хэр бүрдсэн, ямар хэлбэрийн тэсвэртэй байдал илүү ажиглагдаж буйг дүрс зургийн аргаар тодруулж, бүлгийн ярилцлагын аргаар бататгаж, үр дүнг шинжилсэн.

Судалгааны үр дүнгээр Монгол ээжүүд агаарын бохирдлоос үүдэлтэй өдөр тутмын асуудлууд, түүний үр дагавраас урьдчилан сэргийлэх, дасан зохицох, даван туулах **арга хэмжээг маш идэвхтэй авч хэрэгжүүлдэг** болох нь харагдсан.

Ялангуяа “бага насны хүүхэдтэй ээжүүд” агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлыг даван туулах чиглэлд тун проактив байна. Харин авч буй арга хэмжээнд уламжлалт аргууд зонхилдог бөгөөд судалгаа, шинжлэх ухаанд суурилсан арга аргачлалуудыг ашиглаж буй байдал бага байна.

Ээжүүд урьдчилан сэргийлэх, даван туулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ ижил насны хүүхэдтэй бусад ээжүүд, найз нөхөдтэй холбогдох, бие биетэйгээ туршлага солилцох, мөн хамаатан садан, ахмад настай хүмүүсээс зөвлөгөө авах, туршлагаас нь суралцах зэргээр **ээжүүд хоорондын холбоо, харилцаа** энэ үед нэмэгддэг нь ээжүүдийн хувьд нийгмийн капитал болж, бүлгийн тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг байна. Ээжүүд хоорондоо дасан зохицох, даван туулах мэдлэг, мэдээлэл, туршлага зэрэг нөөцүүдээ хуваалцах үйл явц зөвхөн агаарын бохирдлын идэвхтэй үед гэлтгүй **жилийн дөрвөн улиралд тасралтгүй явагдаж байгаа** нь ээжүүдийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээ проактив шинжтэй байгааг харуулж байв.

Хүснэгт 2. Тэсвэртэй байдлын ангилал

Реактив тэсвэртэй байдал	Проактив тэсвэртэй байдал
Тохиосон гамшиг, эрсдэлд шууд хариу арга хэмжээ авах буюу нөхцөл байдлыг эргэн хэвийн байдалд оруулахад төвлөрдөг. Үүний тулд шуурхай арга, цаг алдахгүйгээр үр ашигтай, бодитой, биет хариу арга хэмжээ, зохион байгуулалтыг хийхэд илүү төвлөрдөг.	Системийн ерөнхий зорилго, харилцан уялдаа холбоотой байхад төвлөрөн аливаа байгалийн гамшиг эрсдэлийг урьдчилан таамаглаж, өмнөх туршлагаудаа тулгуурлан турших, сайжруулах, суралцах, бэлтгэлтэй байх тасралтгүй үйл явц. Зорилго нь ирээдүйд урт хугацаандаа тогтвортой хэрэгжих арга замыг тодорхойлоход төвлөрдөг.

Агаарын бохирдлоос үүдэлтэй өдөр тутмын асуудлуудыг даван туулах чиглэлд ээжүүд хэр тэсвэртэй вэ?

Агаарын бохирдлоос үүдэлтэй хамгийн том бэрхшээл бол ээжүүдийн хувьд хүүхдийн өвчлөл юм. Ялангуяа агаарын бохирдлын нөлөөгөөр ханиад, томуу, томуу төст өвчин агаарын бохирдолгүй байх үеэс эрчимтэй өсдөг. Монгол Улсад жилд 300 орчим хүн агаарын бохирдлоос үүдэлтэй өвчний улмаас нас бардгийн 80% (n=240) гаруй нь тав хүртэлх насны хүүхэд бөгөөд хүүхдийн өвчлөлд амьсгалын тогтолцооны өвчин үнэмлэхүй жин дарж байна (Mongolia, 2023). Улмаар амьсгалж буй агаарын бохирдол хэт өндрөөс хүүхдүүдийн уушгины чадавх нийтлэг муудаж, өвчлөлийн давтамж нэмэгдэж, эдгэрэх үйл явц удаашралтай, зарим үед нэг төрлийн вирусээр үүсгэгдсэн ханиадны дараа өөр төрлийн ханиад хүрэх зэргээр өвчлөлийн үйл явц олон хоногоор үргэлжилдэг нь ээжүүдийн хувьд хамгийн тулгамдсан асуудал болдог.


Азийн бусад орнуудтай ижлээр Монгол эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл төвт хандлага хүчтэй илэрдэг. Тухайлбал, Монгол эмэгтэйчүүдийг эрүүл байхад нөлөөлж буй хүчин зүйлсийг жагсаахад хамгийн их жинг тэдний хүүхдүүд болон гэр бүлийн аз жаргал (19.5%) эзэлсэн байдаг. Энэ нь амьдралын хэв маяг, эрүүл мэндийн мэдлэг, ажил орлого, санхүү зэрэг бусад үзүүлэлтээс илүү гэр бүлийн нөхцөл байдал нь эмэгтэйчүүдийн хувьд өндөр ач холбогдолтой, энэ нь шууд бус байдлаар

ээжүүдийн сэтгэл зүй болон бие махбодын эрүүл мэндэд нь нөлөөлж байдгийг илтгэнэ (ЗСДС, 2021).

Судалгаанд хамрагдсан ээжүүдийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь зөвхөн агаарын бохирдлын идэвхтэй үеэс гадна жилийн бүх л улиралд тасралтгүй явагдаж байсан. Энэ нь асуудал тохиосны дараа гэхээс илүүтэй тохиох боломжтой эрсдэлд урьдчилан бэлдэх, тасралтгүй бэлэн байдлаа хангах буюу проактив тэсвэртэй байдлын хандлагыг илэрхийлж байсан. Тухайлбал:

- Зун, агаарын бохирдол багатай үед цэвэр агаартай газар хүүхдүүдээ аваачих, цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэх болон биеийн ерөнхий дархлааг сайжруулах уламжлалт аргууд (айргаар шавших, хар цайнд оруулах...)-ыг нийтлэг ашиглаж,
- Намрын улиралд дархлаа дэмжих хүнсний нөөцөө бүрдүүлэх, хадгалах
- Хаврын улиралд улирлын шилжилт эрчимтэй явагдаж буй үед нойроо сайн авах, шөлтэй, үхрийн махтай буюу уураг ихтэй хоол сайн идэх, эрт нимгэлэхгүй байж дулаанаа хадгалах,
- Өвлийн улиралд нэмэлт витамин, дархлаа дэмжих эмэн болон эмэн бус аргуудыг хэрэглэх, амралтын өдрүүдээр хотоос гарч цэвэр агаарт амрах, мөн дархлаа дэмжих халуун, шөлтэй хоол хүнсний хэрэглээг нэмэгдүүлэх (халуун аарц, чацаргана, шөлтэй хоол...) арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Зураг 9. Цэвэр агаар бол тангаглал



Зургийн тайлбар: Нөхөр бид 2 ажил ихтэй байдаг учир хааяа амралтын өдрүүдэд хүүхдүүдтэйгээ агаарт гарахыг хичээдэг. Маш их тоосжилт, агаарын бохирдол дунд уушги нь их гэмтэж байгаа болохоор болж өгвөл агаарт гаргадаг. Агаарт байж байгаад хот руу орж ирэхэд маш эвгүй муухай үнэр үнэртдэг.

Зураг 10. Дархлаа дэмжих уламжлалт аргуудаас



Зургийн тайлбар: Хүүхдийнхээ дархлааг дэмжихийн тулд 7 хоногт 3-4 удаа аарц, чацаргана, аньс буцалгаж өгдөг. Ханиад хүрэх үед нь хөнгөхөн дархлааг нь дэмжээд өгвөл хүндрэх нь бага байдаг. Өвөл маш их аарц, чацаргана ордог тул зун, намартаа хөдөөгөөс бэлдэж ирдэг.

Ээжүүдийн тэсвэртэй байдалд тэдний нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарсан ялгаа бий эсэхийг тодруулахад:

- Орон сууцанд амьдардаг ээжүүдээс илүү гэр хороололд амьдардаг ээжүүд
- Ганц бие ээжүүдээс илүү цөм гэр бүлтэй ээжүүд
- Нэг хүүхэдтэй ээжтэй харьцуулахад нэгээс олон бага насны хүүхэдтэй ээжүүдийн тэсвэртэй байдал, арга хэмжээ авах хандлага илүү идэвхтэй байна.

Судалгаанд хамрагдсан ээжүүдийг харьцуулбал гэр хороололд амьдардаг ээжүүд агаарын бохирдлын асуудал, түүнийг шийдэх арга

замуудыг эрэлхийлэх тал дээр орон сууцанд амьдардаг бүлгүүдтэй харьцуулахад илүү идэвхтэй хандаж байна. Тухайлбал зөвхөн хүүхдүүддээ төвлөрөхөөс гадна бохирдлыг бууруулах чиглэлд “түлшний хэрэглээгээ бууруулж, цахилгаан халаалттай байшин барих, халаагуур ашиглах, хашаандаа мод тарих г.м”. Гэр хорооллын ээжүүд бол агаарын бохирдлын хүчтэй хохирогч болж буй талууд болохоос гадна агаарын бохирдолд тодорхой хэмжээнд хувь нэмэр оруулж буй гэсэн мэдрэмжтэй байгаа тул сууцны хорооллын ээжүүдтэй харьцуулахад илүү олон талт аргуудыг ашиглаж байгаа нь ажиглагдсан.

“...Гэрээ цахилгаанаар халаадаг. Улиастайд гэрт амьдарч байгаа үед ч бас галлагаатай байхаар үнс, тортог ихтэй өөрсдөө агаарын бохирдол дунд ороод байдаг учраас гэр доторх агаарын бохирдлоо багасгасан дээр юм байна гээд 100 хувь цахилгаанаар халдаг байшин барьж эхэлж байгаа.”

Хүснэгт 3. Агаарын бохирдлоос үүдэлтэй тулгамдаж буй асуудлуудыг даван туулахын тулд ээжүүдийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд

Агаарын бохирдлоос үүдэлтэй ээжүүдэд тулгамдаж буй асуудлууд	Урьдчилан сэргийлэх аргууд	Хамгаалах, даван туулах аргууд
<p>Эрүүл мэнд:</p> <ul style="list-style-type: none"> -Хүүхэд өвдөх, өвчлөх давтамж нэмэгдэх -Ээжийн өөрийнх нь эрүүл мэндийн асуудлууд, ханиад хүрэх, толгой өвдөх, дархлаа муудах, архаг өвчлөлүүд үүсэх, төрөхийн хүндрэл г.м -Стресс, сэтгэл зүйн хямрал, нойргүйдэл, сэтгэл гутралд орох 	<p>Эрүүл мэнд:</p> <ul style="list-style-type: none"> -Хүүхдүүдээ хөдөө, цэвэр агаартай газар зуны улиралд дархлаажуулах -Уламжлалт аргуудаар хүүхдүүдийн дархлааг дэмжих: хар цай, айраг, ясны шөлөнд оруулах, ганга, цагаан гаа, давс, сод, бор цайнд оруулах болон хөлийг дүрэх г.м -Дархлаа дэмжих иллэг, массаж, тос түрхэх (адуу, баавгайн тос), бариа, татлага, утлага хийлгэх -Агаар цэвэршүүлэх аргуудыг турших: Мод, ногоон ургамал тарих, зуухан дээр ус буцалгах, сармис усанд тавих, г.м -Шажмал түлшний хэрэглээгээ бууруулах хувилбаруудыг сонгох: Гэрээ дулаалах, цахилгаан халаагуур хэрэглэх 	<p>Эрүүл мэнд:</p> <ul style="list-style-type: none"> -Ажил, карьер, боловсрол зэрэг бусад үүргээ орхиж хүүхдүүдээ асрах, эмчлэх аргуудыг авч хэрэгжүүлэх, гэрээр болон эмнэлгийн байгууллагад хэвтэн эмчлүүлэх -Гэр бүлийнхнээс дэмжлэг авах
<p>Нийгмийн харилцаа:</p> <ul style="list-style-type: none"> -Тогтвортой ажил эрхлэх боломжгүй байх, бүтээмж буурах -Найз нөхөд, нийгмийн харилцаа буурах, хүрээлэл багасах 	<p>Нийгмийн харилцаа:</p> <ul style="list-style-type: none"> -Хүүхдийн өвчлөл нэмэгдэхийг харгалзаж ээлжийн амралтаа өвлийн үеэр төлөвлөх, ажлаасаа чөлөө авах, найз нөхөд болон бусад нийгмийн хүрээлэлдээ зарцуулах цагаа бууруулах, гэр бүлийнхнээс дэмжлэг авах, 	<p>Нийгмийн харилцаа:</p> <ul style="list-style-type: none"> -Нийгмийн хүрээлэл өөрчлөгдөж илүү ижил асуудалтай ээжүүдээр санхүүгийн дэмжлэг нэмэх -Найз нөхөдтэйгөө уулзах үед гэр бүлийнхний дэмжлэгийг авах
<p>Эдийн засаг:</p> <ul style="list-style-type: none"> -Төлөвлөгдөөгүй зардлууд нэмэгдэх, санхүүгийн ачаалал үүсэх 	<p>Эдийн засаг:</p> <ul style="list-style-type: none"> -Цагийн, зайнаас хийж болох ажлуудыг хайх, эсвэл хувийн бизнес эрхлэх, өрхийн бусад зардлуудаа бууруулах, хэмнэх 	<p>Эдийн засаг:</p> <ul style="list-style-type: none"> Гэр бүлийн бусад гишүүдийн санхүүгийн дэмжлэг, орлогод тулгуурлах
<p>Боловсрол:</p> <ul style="list-style-type: none"> -Хувийн хөгжил, карьер, ажил, боловсролд зарцуулах цаг огцом багасах 	<p>Боловсрол:</p> <ul style="list-style-type: none"> -Цахим сургалтуудад хамрагдах 	<p>Боловсрол:</p> <ul style="list-style-type: none"> -Цахим сургалтуудад хамрагдах -Агаарын бохирдлын идэвхтэй үед авах арга хэмжээ огцом багасдаг.

Тулгамдсан асуудлаа даван туулахын тулд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлдэг вэ?

Хүүхдийн өвчлөлөөс үүдэлтэйгээр эдийн засгийн, гэр бүлийн, нийгмийн олон асуудлууд дам байдлаар үүсдэг нь ээжүүдэд “ээж”-ийн хувьд үүрэх хариуцлага, ачааллыг ихээр нэмэгдүүлдэг. Иймд ээжүүдийн авч хэрэгжүүлдэг арга хэмжээ нь голлон хүүхдүүдийн ханиад томуунаас сэргийлэх, дархлааг нь дэмжих, өвдсөн тохиолдолд хүндрэл багатайгаар эдгээх арга зам уруу чиглэж байна.

Авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг ангилан авч үзвэл илүү хүүхдэд төвлөрсөн шинжтэй, уламжлалт буюу Монголчуудын хэлдгээр “ардын” ухаанд суурилсан аргууд зонхилж байна. Тухайлбал, уламжлалт аргуудад хүүхдийг усанд оруулах төрөл бүрийн аргууд, дархлаа дэмжих хоол хүнсээр эмчлэх,

гэрийн аргаар агаар чийгшүүлэх, тос түрхэх, бариа, татлага, утлага хийлгэх зэрэг болно. Эдгээр уламжлалт арга хэмжээний талаарх мэдээллийг авдаг гол эх сурвалж нь фейсбүүк дээрх ээжүүдийн групп, эцэг эх, найз нөхдийн группүүд байна. Өөрөөр хэлбэл, судалгаа, албан эх сурвалжийн мэдээллээс илүүтэй ижил асуудалтай ээжүүдийн туршлага (experience)-д суурилсан байдлаар шинэ мэдлэг мэдээлэл, арга аргачлалуудад суралцдаг байна.

Харин агаарын чанарыг хэмждэг, түүнд үндэслэн арга хэмжээгээ уялдуулдаг, агаарын бохирдлыг бүрдүүлж буй нэгдлүүд, түүнийг бий болгогч эх үүсвэрүүд (гэр хороолол, тээврийн хэрэгслээс бусад)-ийг ялгах, тэдгээрийн эрүүл мэндэд учруулах нөлөөг таних, тэдгээрт чиглэсэн арга хэмжээг авах зэргээр судалгаа, шинжлэх ухааны мэдээлэлд үндэслэн арга хэмжээ авах байдал ээжүүдийн дунд бага ажиглагдлаа.

“...Ахмадуудын зөвлөгөө болон олон нийтийн сүлжээнээс голцуу мэдээллээ олж харж, уншиж мэдэж авдаг. Тодруулбал: ээжүүдийн групп, эцэглэгийн групп, найз нөхдийн групп гэх мэт. Ганга болон ханиаданд адууны тос түрхэх, сонгино хөлд тавих, сармис усанд хийж өрөөндөө тавих, аарц чацаргана буцалгах гэх мэт аргуудаар дөнгөж эхэлж байгаа анхан шатны үед бол үр дүнтэй санагддаг. Голдуу энэ мэдээллээ олон нийтийн сүлжээ болон хамаатан садныхаа зөвлөгөөг даган хэрэгжүүлдэг.”

“...Мэдээллийг фейсбүүкээс авна, мөн өөрийнхөө бодлоор ингэчихвэл дархлаа нь сайн байх болов уу, ингэчихвэл утаагаар арай бага амьсгалах болов уу гэсэн бодлоороо л явна. 10 дугаар сард бага зэрэг сэрүү ороод эхлэхээр хүүхдүүдийнхээ ар нуруу уушиги хавиар дом болгоод баавгайн тос түрхдэг. Баавгай өөрөө их зузаан арьстай амьтан байдаг гэсэн баавгай шиг зузаан арьстай өвөлжиг гээд л тосолчихдог”

БҮЛЭГ #3

Ээжүүдийн тэсвэртэй байдал дах нийгмийн капиталын нөлөө

Сэмпсон, Рауденбаш, Еэрлс нарын (1997) судалгаанаас харахад нийгмийн капитал нь ээжүүдийн тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, асуудлаа даван туулахад нь чухал үүрэг гүйцэтгэдэг ажээ. Нийгмийн капитал гэдэг нь хувь хүн нийгмийн сүлжээгээрээ дамжуулан авч буй аливаа нөөц, дэмжлэг, холбоо харилцааг ойлгож болдог (Putnam, 2000). Ээжүүд нь өөрсдийн тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, асуудлаа шийдвэрлэхийн тулд ойр дотны, дамжуулах, холбох (bonding, bridging, linking) үүрэг бүхий нийгмийн капиталуудыг ашиглаж байна. Ойр дотны хүрээнээсээ дэмжлэг авснаар

(ойр дотны) нийгмийн ялгаатай бүлгүүдтэй холбогдож (дамжуулах), улмаар гадаад нөөц, боломж, үйлчилгээнүүдийг (холбох) авах боломж бүрдэн, улмаар ээжүүдийн хувьд өөрсдийн өмнө тулгарч буй аливаа сорилтуудыг чиглүүлэхэд туслахуйц хүчтэй дэмжлэгийн сүлжээг бий болгон, аливаа саад бэрхшээлийн үед тэсвэртэйгээр даван гарах чадавхтай болдог ажээ.

Дараах дүрсэд агаарын бохирдлоос үүдэлтэй сорилтуудыг даван туулж, өөрсдийн тэсвэртэй байдлыг хангахын тулд ээжүүд нийгмийн капиталыг хэрхэн ашиглаж байгааг харууллаа.

Дүрс 4. Ээжүүдийн нийгмийн капитал, нийгмийн капиталын төрлөөр, ойр дотны, дамжуулах, холбох үүрэг бүхий нийгмийн капиталууд

Ойр дотны (Bonding)

- Гэр бүлийн гишүүд болон хадмууд нь ээжүүдийн үүрэг хариуцлагыг хуваалцахад чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Агаарын бохирдолтой улирлуудад ээжүүд ойр дотны найзууд эсвэл гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхэд харах, асруулах ажлуудад дэмжлэг авч байна.
- Ээжүүдэд гэр бүлийн гишүүд болон амьдарч буй орчин дах бусад ээжүүд нь хамгийн ойрын бүлэг болж байна.
- Эцэг эхийн хэн нэг нь байхгүй байгаа үед гэр бүлийн гишүүд хоорондоо шаардлагатай нөөцүүдээ хуваалцаж байна (гол төлөв аавууд эзгүй байна)

Дамжуулах (Bridging)

- Ээжүүдийн онлайн харилцаа нь тэдний хүн хоорондын харилцааг орлон нөхөж байна.
- Онлайн платформууд нь бусад ээжүүдтэй мэдээлэл, дадлаа хуваалцах боломжийг олгож байна.
- Цөөн хэдэн оролцогчид нийгмийн бүлгүүд эсвэл спортын клубүүдэд нэгдэх замаар өөрсдийн стрессийг бууруулдаг гэжээ.

Холбох (Linking)

- Орон нутгийн залуучуудын зөвлөлд ганцхан ээж оролцож, бусад ээжүүд болон хамт олныхоо өмнөөс дуу хоолойгоо илэрхийлдэг гэжээ.
- Нийгмийн капитал дутагдаж байна.
- Ээжүүдийн хэрэгцээнд тохирсон нөөц бололцоо, дэмжлэгийг дутмаг байна.

Ойр дотнын нийгмийн капитал (bonding social capital) гэдэг нь хүн ам зүйн шинж чанар, боломжит мэдээлэл, нөөц бололцооны түвшин нь ижил төстэй бүлэг, хамт олон доторх холбоог хэлдэг (Клариж, 2018). Ойр дотнын нийгмийн капитал дотор, ээжүүдийн үүргийг хуваалцаж буй гэр бүлийн гишүүд, өөрийн болон хадам ээжийн оролцоо нийтлэг гарч ирж байна. Ялангуяа, агаарын бохирдолтой үеүдэд ээжүүд хүүхдээ харуулах зорилгоор гэр бүлийнхнийхээ дэмжлэгийг түлхүү авч байгаа бөгөөд тулгамдсан үед энэхүү ойр дотнын нийгмийн капитал ихээхэн дэмжлэг болдгийг онцлон дурджээ. Түүнчлэн, гэр бүлийн гишүүдээс гадна амьдарч буй орчин дах ээжүүд хоорондын харилцаа ихээхэн ойр байгааг дурдан, нэн ялангуяа бие биедээ харилцан туслах, хамааралтай байх мэдрэмжүүдээ тэднээс авч байгаа нь харагдаж байна. Өрх толгойлсон ганц бие ээжүүдийн хувьд хамаатан садан нь гол дэмжлэг болж, нөөцөө хуваалцаж байна. Харин ээжүүдийн хувьд өвлийн улиралд гэр бүлийн хүрэнээс гадуурх найз нөхдийн биечилсэн харилцаа буурч байгаа хандлага нийтлэг ажиглагдсан.

Дамжуулах үүрэг бүхий нийгмийн капитал (bridging social capital) гэдэг нь олон янзын нийгмийн бүлгүүдтэй холбогдохыг хэлнэ (Клариж, 2018). Судалгаанаас харахад ээжүүд онлайн харилцаанд идэвхтэй байгаа нь тэдний өдөр тутмын хүн хоорондын харилцааг мэдэгдэхүйц нөхөж, бусадтай холбогдох талбарыг бий болгож, өөрийн ойрын хүрэнээс гадуур хүмүүстэй туршлагаа хуваалцаж боломжийг олгож өгдөг. Онлайн платформууд нь ээжүүдийн мэдлэг боловсрол, дэмжлэгийн сүлжээг баяжуулан бусад ээжүүдтэй мэдээлэл, туршлагаа солилцох боломжийг олгодог. Түүнээс гадна, цөөн хэдэн оролцогчид олон янзын нийгмийн бүлгүүдтэй холбоо тогтоохын тулд нийгмийн бүлгүүд эсвэл спортын клубүүдэд элсэх замаар өөрсдийн стрессийг тайлдаг гэжээ. Гэсэн хэдий ч онлайн болон биечилсэн харилцааны ач холбогдлыг үл харгалзан олон нийтийн дунд ээжүүдэд зориулсан нөөц

бололцоо, дэмжлэг, арга хэмжээ бага байгаа нь илэрхий байлаа. Энэхүү байдал нь ээжүүдийг нийгмийн илүү өргөн цар хүрээний бүлгүүдтэй хамтран ажиллах боломжийг хязгаарлаж, хүчтэй нийгмийн капиталыг бий болгох боломжийг бууруулж байдаг байна.

Холбох үүрэг бүхий нийгмийн капитал (linking social capital) гэдэг нь эрх мэдэл бүхий байгууллага эсвэл хувь хүмүүстэй холбоо тогтоохыг хэлнэ (Stone & Hughes, 2002). Тэдгээрээр дамжин нэмэлт дэмжлэг эсвэл нөөцөөр хангадаг аливаа үйлчилгээ, хөтөлбөр эсвэл нөлөөллийн бүлгүүдэд нэгдэн орсноор ээжүүд холбох үүрэг бүхий нийгмийн капиталын ач холбогдлыг мэдрэх боломжтой. Ийм холбоо нь ээжүүдийн дунд ихэвчлэн бага байгаа нь ээжүүдийн онцлог хэрэгцээнд тохирсон нөөц, дэмжлэг дутагдалтай, мөн нөгөө талд энэ төрлийн нийгмийн капиталд өгөх ээжүүдийн анхаарал, ач холбогдол ч бага байсан. Жишээ авбал, засаг захиргааны анхан шатны нэгжид ажилладаг нэг ээж дүүргийнхээ залуучуудын зөвлөлтэй хамтран ажиллах санаачилга гаргасан байсан. Энэхүү зөвлөлийн ажлаар дамжуулж тэрээр бусад ээжүүдийнхээ өмнөөс тэдний санааг зовоодог, тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэхийг зорьж байгаа. Гэвч түүний хичээл зүтгэлээс үл хамааран, ганцаархнаа төлөөлж байгаа байдал нь ялгаатай бүлгийн ээжүүдийн ялгаатай хэрэгцээг үр дүнтэй хангахад хязгаарлагдмал байдлыг үүсгэдэг байна.

Түүнээс гадна, агаарын бохирдол ихтэй үед ээжүүдийн үүрэг хариуцлага, нийгмийн оролцоо ихээр буурч байгаа нь илэрхий хэдий ч ээжүүдийн сэтгэл зүй, боловсрол, нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн зорилтот болон тэгш хүртээмжтэй нийгмийн хөтөлбөр, санаачилга, арга хэмжээ маш бага байна. Өөрөөр хэлбэл, олон нийтэд нийгмийн капиталыг сайжруулах ажлууд зайлшгүй шаардлагатай байна. Зориулагдсан нөөц, санаачилга дутмаг үед эдгээр хүнд нөхцөл байдлыг ээжүүд дан ганц ойр дотны тусламж, дэмжлэгээр туулж байгаа юм.

Дүгнэлтийн оронд

“Улаанбаатар хотод амьдардаг ээж, тодруулбал бага насны хүүхэдтэй бол хувь хүнээс өөрөөс үл хамаармалаар хүйтний эрч чангарч, агаарын бохирдол нэмэгдэхтэй зэрэгцэн тэдний сайн сайхан байдал огцом буурч байна”.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүний сайн сайхан байдлыг хэмждэг шалгуур үзүүлэлтээр Улаанбаатар хотод амьдардаг ээжүүдийн сайн сайхан байдлыг судлахад 10 шалгуур үзүүлэлтээс эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн харилцаа, боловсрол гэсэн 4 хэмжээс нь агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлуудад хамгийн хүчтэй өртөж байгааг судалгааны үр дүн харууллаа. Агаарын бохирдлын үед ээжүүдийн өдөр тутмын амьдралын хэмнэл, хэв маягт мэдэгдэхүйц өөрчлөлт ордог. Ээжүүд эдийн засгийн хувьд илүү дарамтад орж, нийгмийн харилцаа нь багасахаас гадна өөрийн болон өрхийн гишүүдийн боловсрол, эрүүл мэндээс үүдэлтэй олон асуудалтай тулгарч байна. Эдгээр шалтгаанаас үүдэж ээжүүдэд сэтгэл хөдлөл багасах, сэтгэл санаагаар унах, амьдралын сэтгэл ханамж буурах хандлагууд ажиглагдаж байна.

Угтаа агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлуудыг даван туулахад ээжээс хувь хүнээс хамаарах оролдлого, хичээл зүтгэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ маш идэвхтэй байсан нь уг судалгааны нэг чухал үр дүн байв. Тэд агаарын бохирдлоос үүдэлтэй асуудлуудыг даван туулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, алхмуудыг жилийн 4 улиралд авч байдаг. Гэсэн хэдий ч тэдний хичээл зүтгэлээс үл хамааран хүүхдийн эрүүл мэндийн байдал муудаж, хүндэрвэл ээжүүд нийтлэг өөрсдийгөө буруутгаж, хувь хүний түвшинд асуудлын шалтгааныг хүлээж авдаг. Гэвч энэхүү асуудлын шалтгаан нь хувь хүнээс илүүтэйгээр нийгэм, орчны хүчин зүйлээс үүдэлтэй юм.

Нэгэнт тулгарсан Улаанбаатарын “утаа”-наас үүдэлтэй асуудлуудыг даван туулахад нийгмийн капиталын үүрэг маш чухал нөлөөтэй. Судалгаагаар ээжүүдэд нийгмийн капиталтай холбоотой ажиглагдсан онцлог хоёр үр дүн байсан. Нэгдүгээрт, гэр бүл, эргэн тойрны дэмжлэг сайтай байх хэрээр ээжүүдийн тэсвэртэй байдал сайн байх эерэг хамааралтай байна. Хоёрдугаарт, ижил асуудалтай ээжүүд хоорондын идэвхтэй харилцаа нь ээжүүдийн хувьд онцлог нийгмийн сүлжээг үүсгэж байв. Иймд ээжүүдийн ачааллыг хуваалцахын тулд гэр бүлийн бусад гишүүдэд чиглэсэн нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэх, ижил асуудалтай ээжүүдийн бүлгийг “Дэмжигч бүлэг/Community support network” хэлбэрээр хөгжүүлэх, дэмжих нь ээжүүдийн сайн сайхан байдлыг дэмжихэд ач холбогдолтой байж чадахаар байна. Ингэхдээ нийтлэг ашиглаж буй уламжлалт урьдчилан сэргийлэх болон хамгаалах аргуудын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбар мэдээлэл өгөх, ээжүүд өөрсдөө судалгаа хийх, судалгаандаа үндэслэж тохиромжтой асаргааны арга барилаа тодорхойлох, шинжлэх ухааны аргуудтай зан үйлээ холбох буюу агаарын бохирдлын хэмжээг үнэлж, хариу арга хэмжээтэйгээ уялдуулдаг байх чиглэлээр ээжүүдийг чадавхжуулах хэрэгцээ байна.

Энэхүү судалгаа нь арван ээжийн амьдралын туршлага, баримтад тулгуурласан хэдий ч чанарын судалгааны онцлог болох нийгмийн асуудлын ерөнхий хэв маяг (social pattern)-ийг илэрхийлэхүйц сонирхолтой бөгөөд онцлог үр дүнгүүдийг харуулсан юм. Судалгааны үр дүнд үндэслэн хүүхэдтэй ээжүүдийн оролцоог хангах нийгмийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрүүдийг бодлогын болон хөгжлийн төсөл хөтөлбөрийн түвшинд эхлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх боломж, орон зай өргөн байгааг судалгааны багийн зүгээс тодотгох байна.

Ашигласан материалын жагсаалт

- ADB (Asian Development Bank). 2017. *Mongolia: Country Partnership Strategy (2017–2020)*. Institutional Document, April. Manila, Philippines: Asian Development Bank. Retrieved November 22, 2024 (<https://www.adb.org/sites/default/files/institutional-document/182891/mongolia-cps-2017-2020.pdf>).
- Aspinwall, Lisa G., and Shelley E. Taylor. 1997. "A Stitch in Time: Self-Regulation and Proactive Coping." *Psychological Bulletin* 121(3):417–36.
- Bourdieu, Pierre. 1986. "The Forms of Capital." Pp. 241–58 in *Handbook of Theory and Research for the Sociology of Education*, edited by J. Richardson. New York: Greenwood.
- Chuluun, T., Graham, C., & Myanganbuu, S. (2016). Who is happy in the land of eternal blue sky? Some insights from a first study of wellbeing in Mongolia. *International Journal of Wellbeing*, 49-70.
- Claridge, T. (2018). Functions of social capital – bonding, bridging, linking. *Social Capital Research*.
- Enkhmaa, Davaasambuu, Nicole Warburton, Badrakh Javzandulam, Jadambajav Uyanga, Yarinpil Khishigsuren, Sereeter Lodoysamba, Shonkuuz Enkhtur, and David Warburton. 2014. "Seasonal Ambient Air Pollution Correlates Strongly with Spontaneous Abortion in Mongolia." *BMC Pregnancy and Childbirth* 14:1–7.
- Folkman, Susan, and Judith T. Moskowitz. 2004. "Coping: Pitfalls and Promise." *Annual Review of Psychology* 55(1):745–74.
- OECD. n.d. "Measuring Well-being and Progress." Accessed October 30, 2024. (<https://www.oecd.org/en/topics/measuring-well-being-and-progress.html>).
- Putnam, Robert D. 2000. *Bowling Alone: The Collapse and Revival of American Community*. New York: Simon and Schuster.
- Sampson, Robert J., Stephen W. Raudenbush, and Felton Earls. 1997. "Neighborhoods and Violent Crime: A Multilevel Study of Collective Efficacy." *Science* 277(5328):918–24.
- Stone, Wendy, and Jody Hughes. 2002. "Measuring Social Capital: Towards a Standardized Approach."
- UNICEF Mongolia. 2023. *Impact of Air Pollution on Maternal and Child Health: Milestones and Innovations*. Report, April. Ulaanbaatar, Mongolia: UNICEF Mongolia. Retrieved November 20, 2024 ([https://www.unicef.org/mongolia/media/5071/file/Impact%20of%20Air%20Pollution%20on%20Maternal%20and%20Child%20Health%20Project%20\(2018-2023\).pdf](https://www.unicef.org/mongolia/media/5071/file/Impact%20of%20Air%20Pollution%20on%20Maternal%20and%20Child%20Health%20Project%20(2018-2023).pdf)).
- World Health Organization. 2018. "World Health Organization Issues Recommendations to Tackle Health Impacts of Air Pollution in Mongolia." Retrieved October 30, 2024. (<https://www.who.int/mongolia/news/detail/28-02-2018-world-health-organization-issues-recommendations-to-tackle-health-impacts-of-air-pollution-in-mongolia>).
- YRF (Young Researcher's Foundation). 2021. "Quality of Women's Life." *Friedrich-Ebert-Stiftung Mongolia*. Retrieved November 20, 2024 (<https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/15372.pdf>).

Фото зургийн эвлүүлэг

